



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 10 сарын 05

№ 34/1

Улаанбаатар
хот

"Байгалийн өгөөж" үйлдвэр
байгуулах тухай

БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийг
үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. Ажилгүйчүүцийн эрхийг хамгаалах хөдөлгөөний дэргэд ажил-
лаж байсан модны аж ахуйн зохион байгуулалтыг өөрчлөн ой цэвэр-
лэх журмаар түлшний мод бэлтгэх, ойн цагалт баялаг ашиглах,
ой нөхөн сэргээх үүрэг бүхий "Байгалийн өгөөж" үйлдвэр /УҮГ/-ийг
байгуулсугай.

2. "Байгалийн өгөөж" үйлдвэрийн дүрмийг хавсралт ёсоор ба-
талсугай.

3. Тус үйлдвэрийг цаашид хувьчлах тухай асуудлыг 1992 онд
багтаан шийдвэрлэхийг хотын Өмч хувьчлалын комисс /н.Ганхуяг/-т
цаалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогцуулан "Хотын ажил эрхлээ-
гүй иргэдийг ажлын байраар хангах тухай" БНМАУ-ын Хөдөлмөрийн
яам, Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991
оны 34/41 дүгээр тогтоолын I дүгээр зүйлийн /...Модны аж ахуй.../
гэснийг хүчингүй болсонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Л.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАЙХАН



Улаанбаатар хотын Ардын Хурлын
гүйцэтгэх захиргааны 1991 оны
344 тоот тогтоолын хавсралт

"БАЙГАЛИЙН ӨГӨӨЖ" /УУГ/ ҮЙЛДВЭРИЙН Д Ү Р Э М

Нэг. Нийтдэг үндэслэл.

1.1. Байгалийн өгөөж үйлдвэр /цаашид үйлдвэр гэх/ нь бие даан үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаагаа явуулах улсын үйлдвэрийн газар юм.

1.2. Үйлдвэрийн газар нь Улаанбаатар хотын Найрамдлын дүүрэгт байрлаж ногоон бүсэд уламжлалт гар аргаар ой цэвэрлэх арчлах журмаар түлшний мод бэлтгэх, ойн дагалт баялгийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулах үүрэгтэйгээр ажиллана.

1.3. Үйлдвэр нь өөртөө албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэж, банкнд харилцах цанстай байна.

1.4. Үйлдвэр нь хөдөлмөрийн цотоол журмаа боловсруулан мөрдөж ажиллана.

Хоёр. Үйлдвэрийн эд хөрөнгө.

2.1. Үйлдвэрийн газрын эд хөрөнгө нь үндсэн сан, эргэлтийн хөрөнгө, санхүүгийн бусад нөөцөөс бүрдэх бөгөөд эх үүсвэр нь улсын болон хотын төсөв, бүх төрлийн зээл, бүтээгдэхүүн ажил үйлчилгээний болон бусад үйл ажиллагаанаас олсон орлого байна.

2.2. Үйлдвэр нь эдэлбэр газартай байж түүнийг зохих хууль тогтоомжийн дагуу ашиглана.

2.3. Үйлдвэр нь өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулах түүнийг арвижуулах үүрэгтэй байх бөгөөд төсвийн болон зээл, тусламжааны шугамаар бий болсноос бусад эд хөрөнгийг бусдад шилжүүлэн худалдах, элэгдлийг тооцож актлах, ашиглалтыг өөрчлөх түрээслэх зэрэг үйл ажиллагаа явуулна.

2.4. Үйлдвэрийг хувьчлахдаа ямар хэлбэрээр зохион байгуулахыг өөрснөө сонгож авна.

2.

Турав. Үйлдвэрийн удирдлага.

3.1. Үйлдвэрийн үйл ажиллагааг үйлдвэрийн дарга удирдаж, Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд тайлагнана.

3.2. Удирдлагын ажлыг ардчилсан, ил тод, хамтч байлгахын тулд захиргааны гишүүдийг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллуулж болно.

3.3. Захиргааны гишүүд тэдгээрийн ажиллах журмыг хамт олны саналыг үндэслэн үйлдвэрийн даргын тушаалаар батлана.

3.4. БНМАУ-ын хууль тогтоомжил нийцүүлэн үйлдвэрийн дарга тушаал заавар гаргаж биелэлтийг зохион байгуулж ажиллана.

Дөрөв. Үйлдвэрийн эрх үүрэг.

4.1. Үйлдвэр нь дүрмээ батлуулж бүртгүүлсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.

4.2. Үйлдвэр нь үйл ажиллагаандаа БНМАУ-ын хууль тогтоомж, төр, засгийн газар, Улаанбаатар хотын хурал, Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны тогтоол шийдвэрүүд болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

4.3. Үйлдвэрийн газрын дарга нь аж ахуйн нэгжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн, 5-ын 1-4-д заасан эрх эзэлнэ.

4.4. Үйлдвэрийн газрын ажиллагсад нь өөрийн үйл ажиллагааны дагуу гарсан хууль тогтоомж, ажлын аргачлал зааврыг ширхэгчлэн биелүүлж ажиллах үүрэгтэй.

4.5. Ой мод бэлтгэх арчлах, цагалт баялгийг ашиглах талаар сургалт явуулж ажиллагсдын мэргэжил мэдлэгийг байнга дээшлүүлж ажиллана.

4.6. Үйлдвэрлэл явуулах талбайд зөвшөөрөл авч тогтоолын хугацаанд ажлаа дуусган ойн байгууллагад газраа хүлээлгэн өгнө.

4.7. Ойн хууль тогтоомжийг ямар нэг хэлбэрээр зөрчих, түймэр гаргах зэргээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

Тав. Үйлдвэрийг байгуулах, татан буулгах.

5.1. Үйлдвэрийн зохион байгуулалтыг өөрчлөх, татан буулгах асуудлыг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.